



ГУРВАНСАЙХАН СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Б.ЭНХТУЯА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgoovi@audit.gov.mn

Эр 16.11.18.

№

01 / 180

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрлын аудитаар нийт 10,951,340.00 /Арван сая есөн зуун тавин нэгэн мянга гурван зуун дөч/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Шатахууны 2,951,340.00 төгрөгийн зардлыг тооцоходоо анхан шатны хүчин төгөлдөр бус баримтаар тооцож зардалд тайлагнасан.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайллан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/ заасныг зөрчсөн.

2. Хяналтын тооллого хийхэд 8,000,000.00 төгрөгийн үнэ бүхий автомашиныг холбогдох байгууллагын шийдвэрлгүйгээр үрэгдүүлсэн, хөрөнгийн дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.2-т /Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг худалдах, шилжүүлэхэд энэ хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна/, мөн хуулийн 73.2-т /Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1707000712

1. Анхан шатны үнэн зөв баримтыг үндэслэн холбогдох журмын дагуу шатахууны тооцоог сар бүр бодож баримтжуулж хэвших, зарцуулалтанд хяналт тавих, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх
2. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоос өмнө үрэгдүүлсэн хөрөнгийн шалтгааныг тогтоож шийдвэрлэх, төлбөр тооцоог хийж дуусгах, шаардлагатай бол холбогдох албан тушаалтныг хууль хяналтын байгууллагад шийлжүүлэн шийдвэрлүүлэх
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 10-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Гурвансайхан сумын Засаг даргын тамгын газрын дарга /Б.Энхтуяа/, нягтлан бодогч Д.Баярцэнгэл нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ



<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллааас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гарасан албан тушаалтныг үүрээт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.